

2024 оны 03 дугаар  
сарын 11-ны өдөр

№: 24/07

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг дүгнэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг,  
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хурлын  
шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг энэхүү тогтоолын хавсралтаар дүгнэсүгэй.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН

“Улсын их дэлгүүр” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 03-р сарын 14-ний өдрийн  
24/07 дугаартай тогтоолын Хавсралт



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА:
  - a. ОРЛОГО: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 7,510,638,000 төгрөгийн түрээсийн орлоготой ажилласан.
  - b. ЗАРДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2024 онд үндсэн үйл ажиллагаандаа 7,172,160,000 төгрөгийн төсөв зарцуулсан.
  - c. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ, АЛДАГДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь дээрх орлого болон зардалд үндэслэн 2023 онд үндсэн үйл ажиллагаанаасаа 338,478,000 төгрөгийн ашиг олсон байна.
2. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА:
  - a. БУСАД ОРЛОГО: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд Нийслэлийн Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 01-р сарын 13-ны өдрийн 001/ХТ2023/00147 дугаартай шийдвэр, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 21-ний өдрийн 210/МА2023/00845 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн 2023 оны 07-р сарын 04-ний өдрийн шүүх хуралдааны 001/ХТ2023/00147 дугаартай тогтоолын дагуу хариуцагч нараас 800,000,000 төгрөгийн төлбөр хүлээн авсан.
  - b. БУСАД ЗАРДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 11-р сарын 15-ны өдрийн 2022/ШЦТ/889 дугаартай шийдвэр, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2023 оны 04-р сарын 06-ны өдрийн 2023/ДШМ/381 дугаартай магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчдийн 2023 оны 07-р сарын 06-ны өдрийн хуралдааны 517 дугаартай тогтоолын дагуу бусдад 1,031,901,000 төгрөгийн төлбөр төлсөн.
  - c. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС АШИГ, АЛДАГДАЛ: “Улсын их дэлгүүр” ХК нь дээрх бусад орлого болон бусад зардалд үндэслэн 2023 онд үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээсэн байна.
3. ЦЭВЭР АШИГ: “Улсын их дэлгүүр” ХК нь 2023 онд үндсэн үйл ажиллагаанаас 338,478,000 төгрөгийн ашиг олж, үндсэн бус үйл ажиллагаанаасаа 231,901,000 төгрөгийн алдагдал хүлээснээр нийт 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
4. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ: 2023 онд 47,572,000 төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байсан ба бодит гүйцэтгэлээр 106,577,000 төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар төлөвлөгөөний биелэлт 224% буюу 124%-иар давуулан биелүүлсэн байна.
5. ДҮГНЭЛТ: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн биелэлтийг хангалттай гэж дүгнэв.